

**БАТЛАВ**  
**ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН**  
**ГАЗРЫН ДАРГА**

**Ш.НОХОЙЖАВ**

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 7-Р СУРГУУЛИЙН ДОТУУР  
БАЙРНЫ ЗӨӨЛӨН ЭДЛЭЛ, ОР, УРЛАГИЙН ЗААЛНЫ  
ТОХИЖИЛТ /ЖАРГАЛАНТ СУМ/  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**Төслийн нэр:** Ерөнхий боловсролын 7-р сургуулийн дотуур байрны зөөлөн эдлэл, ор, урлагийн заалны тохижилт /Жаргалант сум/  
**Төслийн дугаар:** ХОАОНӨГ/202001124

2020 он

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020.09.17

**Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газар** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Ерөнхий боловсролын 7-р сургуулийн дотуур байрны зөөлөн эдлэл, ор, урлагийн заалны тохижилт /Жаргалант сум/** үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хуудсанаас татаж авч болох бөгөөд тендерт оролцох хүсэлтээ [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn). цахим эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгээр **50,000 /тавин мянга/** төгрөгийг тушааж оролцох эрхээ бүртгүүлнэ.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн санал ирүүлэх техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 10:00 цаг**-аас өмнө доорх хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 10:30 минутад Орон нутгийн өмчийн газрын 415 тоот өрөөнд нээлтийг** хийнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх. Тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар  
4 давхар 407 тоот Орон нутгийн өмчийн газрын  
мэргэжилтэн Э.ЦОЛМОН, Утас: 70434401, 88011269  
[www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)**

[www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn),

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |  |
|---|--|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.  |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.<br>2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]   |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.   |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.  |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

<p>ТӨӨЗ-ны холбогдох заалт</p>	<p>Ерөнхий боловсролын 7-р сургуулийн дотуур байрны зөөлөн эдлэл, ор, урлагийн заалны тохижилт /Жаргалант сум/</p>
<p>ТӨӨЗ 1.1</p>	<p>Батлагдсан төсөвт өртөг: 42 500 000 үүнээс 9,750,000 төгрөгийн шууд худалдан авалт хийгдсэн Санхүүжих дүн 32,750,000 төгрөг</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар ирүүлэх</li> <li>2. Нийгмийн даатгалын тодорхойлолт /өр төлбөргүй эсэх, эх хувь /эх хувь, тендер зарласан хугацаанд авсан тодорхойлолт байна/</li> <li>3. Харилцагч банкны тодорхойлолт /эх хувь, тендер зарласан хугацаанд авсан тодорхойлолт байна/</li> <li>4. Татварын хэлтсийн тодорхойлолт шаардлагагүй нээсэн өдрийн байдлаар системээр дамжуулан лавлагааг авч үзнэ. /өр төлбөргүй байх шаардлагатай./</li> <li>5. Шүүх байгууллагын тодорхойлолт /эх хувь, Анхан шатны шүүхээс/ /эх хувь, тендер зарласан хугацаанд авсан тодорхойлолт байна/</li> <li>6. Сүүлийн 1 жилийн хугацаанд нийлүүлсэн туршлагатай байх бөгөөд нийлүүлсэн барааны гэрээ, актыг ирүүлэх,</li> <li>7. Нийлүүлсэн барааны чанарын талаар өмнөх захиалагчийн тодорхойлолт</li> <li>8. Нийлүүлэх барааны загвар тодорхойлолт, гэрэл зураг, тэдгээрийн үнэн болохыг гэрчилсэн баримт бичиг ирүүлэх /алдаагүй, зөрүүгүй илэрхийлсэн байх/</li> <li>9. Бараа нийлүүлэлтийн хуваарийг тендерийн баримт бичигт заагдсан маягтын дагуу гаргаж ирүүлэх</li> <li>10. Захиалагч талаас дээрх мэдээллүүдийг мөн цахим системээр давхар шалгана. Ирүүлсэн мэдээлэл системийн мэдээлэлтэй зөрөх эсхүл нийлүүлсэн бараа нь шаардлага хангахгүй бол гэрээний үүргээ зөрчсөн, худал мэдээлэл ирүүлсэн гэж үзэн холбогдох газарт материалыг хүргүүлж хар жагсаалтад бүртгэгдэх болохыг анхаарна уу.</li> <li>11. Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод гаргацтай байх шаардлагатай.</li> <li>12. Илгээсэн материалыг бүрэн гүйцэд алдаагүй илгээх хариуцлагыг тендерт оролцогч өөрөө хариуцна.</li> <li>13. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын даалгавар, техникийн нөхцлийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн барааг нийлүүлж хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</li> <li>14. Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мөн харилцагч банк, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтсээс лавлагаа авахад татгалзах зүйлгүй тухай мэдэгдэл ирүүлнэ.</li> <li>15. Тендерийн баримт бичигтэй нэг бүрчлэн танилцаж жишиг маягтын дагуу бөглөж ирүүлэхийг анхаарна уу!</li> <li>16. Төсөвт өртөг: 32 750 000 төгрөг</li> <li>17. Дээрх материалуудыг ирүүлээгүй буюу дутуу, шаардлага</li> </ol>

**ТӨЭЗ 2.1** хангаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.  
18.Санхүүгийн 2019 оны тайлан аудитын дүгнэлтийн хамт

	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:
<b>ТӨЭЗ 2.1</b>	Байгууллагын хаяг: <b>Ховд аймаг Жаргалант сум. Нутгийн удирдлагын ордон. Орон нутгийн өмчийн газар</b> Давхар болон өрөөний дугаар: <b>4 давхар 407 тоот өрөө</b> Огноо: <b>2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр</b> Цаг: <b>10 цаг 00 минут</b> Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:
<b>ТӨЭЗ 2.3</b>	Байгууллагын хаяг: <b>Ховд аймаг Жаргалант сум. Нутгийн удирдлагын ордон. Орон нутгийн өмчийн газар</b> Давхар болон өрөөний дугаар: <b>4 давхар 407 тоот өрөө</b> Огноо: <b>2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр</b> Цаг: <b>10 цаг 30 минут</b> Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:
<b>ТӨЭЗ 6.2</b>	<ol style="list-style-type: none"> <li><b>1. Үнийн санал</b></li> <li><b>2. Бараа нийлүүлэх хуваарь</b></li> </ol>
	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Багцгүй.</b>

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

БАТЛАВ

Т.ЖАРГАЛСАХАН

**ХОВД АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ЕБ-ын7 ДУГААР СУРГУУЛИЙН ДОТУУРНЫ БАЙРНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Д/д	Тавилгын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Тодорхойлолт хүчин чадал
<b>Хүүхдийн өрөө</b>				
1	Ширээ /өрөө/	ш	15	Ширээний тавцанг нягт өндөртэй 18мм -ын зузаантай, сайн чанарын шахмал модон хавтангаар хийх бөгөөд тавцангийн ирмэгийг зориулалтын эмжээр ,хуулга болон PVC материалаар өнгөлсөн 2-3 хүүхэд суух боломжтой байна. Ширээний төмөр раман хөл нь профиль квадрат яндан төмөр байх бөгөөд эвхэгддэг хөдөлгөөнт түгжээ бүхий механизмаар эвхэгдэж, дэлгэгддэг зориулалттай байна. Ширээний тавцан төмөр рам хоорондын угсралтыг мебелийн далд шурган холбоосны хэрэгслээр
2	Сандал /өрөө/	ш	52	Сандалны түшлэг болон тавцан нягтрал сайтай үргэлжилсэн модоор хийгдсэн, түшлэгэндээ бариултай, бөөрөний төмөр рам дээр бэхлэгдсэн.
3	Хагас автомат угаалгын машин /9-10 кг/	ш	3	Самсунг 9 кг хагас автомат угаалгын машин /WT90H3 230MG/ Угаах жин хуурайгаар 9.0кгСэгсрэх жин: 4,6кг Хэмжээ нь: /өргөн, өндөр, гүн/ 86x90x50см
4	Хагас автомат угаалгын машин /14 кг/	ш	1	Хуурай жингээр 14 кг угаана,Сэгсрэгч том Бохир ус гадагшлуулах шахуургатай Бат бөх хуванцар биетэй,Усаар шүрших функц Сайжруулсан хог шүүгчтэй Давхар ханатай
<b>Гал тогооны тоног төхөөрөмж</b>				
1	Гал тогооны ширээ	ш	12	Ширээний тавцан 2.5 см зузаан нягтрал сайтай модоор хийгдсэн. Ширээний урт 120см, өндөр 80см, өргөн 70 см, ширээний хөл нь дөрвөлжин төмрөөр хийгдсэн.
2	Гал тогооны сандал	ш	48	Сандалны суудал болон түшлэг нь 2.5 см -ын нягтралтай модоор хийгдсэн. Тавцан 40x40 см. Өндөр нь 95 см. Ерөнхий рам нь төмрөөр хийгдсэн хөлний доод хэсэг нь зөөлөвчтэй.
3	2-р хоолны тогоо	ш	1	Марк: УНЗ-Я 0,25 Овор хэмжээ/урт,өргөн,өндөр/: 830x816x875 Халах горим/С*/: 50-300 С Жин/кг/: 150кг Хүчин Чадал /квт/: 6 кВт Хүчдэл /v/: 380 в Багтаамж: 40 л
4	Ус цэвэршүүлэгч	ш	2	Мaгic Ус цэвэршүүлэгч.Model No:WPU-6200F, хэмжээ:350x438x1230, Солонгос улсад үйлдвэрлэсэн. Цэвэр усны шугаманд шууд холбогддог.
5	Кострол 50 л	ш	1	Зузаан ган төмрөөр хийгдсэн, 50 литрийн багтаамжтай. Бариултай дугуй тагтай
<b>Багшийн өрөө</b>				
1	Багш ширээ	ш	3	Ширээ нь нягтаршил сайтай модоор хийгдсэн.Процессор тавих тавиуртай, босоо 3 ширхэг шүүгээтэй,ширээний тавцан дээр интернет болон процессорын утас орох хэсэгтэй.

5	Принтер / Epson-L311	ш	1	<ul style="list-style-type: none"> <li>• Хувилах: Үргэлжлүүлэн хувилах: 20</li> <li>Ихэсгэж багасгах: 25-400%, Auto Fit Function C</li> <li>Нягтрал: 600 dpi x 1,200 dpi</li> <li>Хэмжээ: 216 x 297mm (8.5 x 11.7")</li> </ul>
6	Канон /хэвлэх машин	ш	1	<p>Цаасны Хэмжээ А5_А4, Хэвлэх Нягтрал:1200*1200 D</p> <p>Принтер Хэвлэх Хэмжээ:А4-Р Хэвлэх</p> <p>Принтер Хэвлэх Өнгө:Хар Цагаан Олон Үйлдэлт Төх</p> <p>Хувилах, Скандах Нягтрал:600*600 Dpi</p> <p>Принтер Үйлдэл:Хэвлэх Хувилах, Скайнер, Фах, Мэй</p> <p>Цаасны Жин:60 - 216 Гр/См3</p> <p>Цаасны Багтаамж:250 Хуудас</p> <p>Хурд:40ppm / А4</p> <p>Ар Өвөргүй Хэвлэх, Хувилах: Автомат</p> <p>Үйлдвэрлэгч Улс:Нидерланд</p> <p>Брэнд Сонголт:хөгөх</p>
<b>Хүүхэд хөгжлийн танхим</b>			<b>Тодорхойлолт хүчин ч</b>	
1	Ширээ	ш	4	Ширээний тавцанг нягт өндөртэй 18мм -ын зузаантаг хавтангаар хийх бөгөөд тавцангийн ирмэгийг зориул PVC материалаар өнгөлсөн 2-3 хүүхэд суух боломжт раман хөл нь профиль квадрат яндан төмөр байх бөг түгжээ бүхий механизмаар эвхэгдэж, дэлгэгддэг зор тавцан төмөр рам хоорондын угсралтыг мебелийн д хэрэгслээр
2	Сандал	ш	16	Сандалны түшлэг болон тавцан нягтрал сайтай хийгдсэн, түшлэгэндээ бариултай, ерөнхий тө
3	Телевизор 40"	ш	2	дэлгэц 40 инч/101,6 см/, Full HD нягтаршилтай
4	Самбар /200 смx120 см	ш	2	/200 смx120 см/
5	Принтер 3 үйлдэлт	ш	2	Олон үйлдэлт лазер принтер USB/LAN/WiFi/ D
6	Номын тавиур /өрөө/	ш	50	олон нүдтэй хананд тогтоох боломжтой, сайн ч хавтангаар хийгдсэн
3	Компьютер суурин /D	ш	2	Процессор/CPU: i7-8700(12M Cache,4.6 GHz),Шуурха 2666MHz (up to 32GB), Хатуу диск/HDD: 1TB 7200 rpm График карт:Nvidia Geforce GTX1050 2GB,Оптик дра and Writes to DVD/CD),Сүлжээ:Integrated Giga bit 10/ 1707 Card [802.11BGN+Bluetooth 4.0, 2.4 GHz], Multit Wired Mouse Black,дэлгэц: 24 инч

ХЯНАСАН: ХОХБТХ-ИЙН ДАРГА

Б.БАЯРСҮХ

БОЛОВСРУУЛСАН: ХОХОБТХ-ИЙН ММЭРГЭЖИЛТЭН

Л.БАТ





2	Багш сандал	ш	3	Төмөр рамтай, түшлэгтэй, түшлэг болон суудал нь зөөлвөчтэй, хөл нь хуванцар хамгаалаттай, гарын түшлэггүй, сайн чанарын төмөр материалаар хийгдсэн, хар өнгөтэй байна. L420 мм x W420мм x H1-400 мм x H2-900мм
3	Компьютер суурин /D	ш	3	Процессор/CPU: i7-8700(12M Cache,4.6 GHz),Шуурхай санах ой/RAM: 8GB BBR4 2666MHz (up to 32GB), Хатуу диск/HDD: 1TB 7200 rpm SATA 3Gb/s Hard Driver, График карт:Nvidia Geforce GTX1050 2GB,Оптик драйв:Tray load DVD Drive (Reads and Writes to DVD/CD),Сүлжээ:Integrated Giga bit 10/100/1000 Ethernet, Wireless: 1707 Card [802.11BGN+Bluetooth 4.0, 2.4 GHz], Multimedia Keyboard - KB216 MS116 Wired Mouse Blak,дэлгэц: 24 инч
4	Принтер хар /3 үйлдэ	ш	2	Олон үйлдэлт лазер принтер USB/LAN/WiFi/ Duplex/ADF-50хуудас
5	Принтер / Epson-L311	ш	1	<ul style="list-style-type: none"> <li>• Хэвлэлт: On-demand ink jet (piezoelectric) 4-colour</li> <li>• Хэвлэх нягтрал хамгийн ихдээ: 5760x1440 dpi (with VSDT)</li> <li>• Хэвлэх хурд:</li> <li>• А4 текст (драфт) дунджаар 33/15ppm (хар/өнгөт)</li> <li>• Фото (default) - 10x15cm/4x6" дунджаар 69 сек (хүрээтэй)</li> <li>• Хувилах: Үргэлжлүүлэн хувилах: 20</li> </ul> Ихэсгэж багасгах: 25-400%, Auto Fit Function Скандардах Нягтрал: 600 dpi x 1,200 dpi Хэмжээ: 216 x 297mm (8.5 x 11.7")
6	Канон /хэвлэх машин	ш	1	Цаасны Хэмжээ А5_А4, Хэвлэх Нягтрал:1200*1200 Dpi Принтер Хэвлэх Хэмжээ:А4-Р Хэвлэх Принтер Хэвлэх Өнгө:Хар Цагаан Олон Үйлдэлт Төхөөрөмж Хувилах, Скандарх Нягтрал:600*600 Dpi Принтер Үйлдэл:Хэвлэх Хувилах, Скайнер, Фах, Мэйл Цаасны Жин:60 - 216 Гр/См3 Цаасны Багтаамж:250 Хуудас Хурд:40ppm / А4 Ар Өвөргүй Хэвлэх, Хувилах: Автомат Үйлдвэрлэгч Улс:Нидерланд Брэнд Сонголт:хегох
Хүүхэд хөгжлийн танхим			Тодорхойлолт хүчин чадал	
1	Ширээ	ш	4	Ширээний тавцанг нягт өндөртэй 18мм -ын зузаантай, сайн чанарын шахмал модон хавтангаар хийх бөгөөд тавцангийн ирмэгийг зориулалтын эмжээр ,хуулга болон PVC материалаар өнгөлсөн 2-3 хүүхэд суух боломжтой байна. Ширээний төмөр раман хөл нь профиль квадрат яндан төмөр байх бөгөөд эвхэгддэг хөдөлгөөнт түгжээ бүхий механизмаар эвхэгдэж, дэлгэгддэг зориулалттай байна. Ширээний тавцан төмөр рам хоорондын угсралтыг мебелийн далд шурган холбоосны хэрэгслээр
2	Сандал	ш	16	Сандалны түшлэг болон тавцан нягтрал сайтай үргэлжилсэн модоор хийгдсэн, түшлэгэндээ бариултай, ерөнхий төмөр рам дээр бэхлэгдсэн.
3	Телевизор 40"	ш	2	дэлгэц 40 инч/101,6 см/, Full HD нягтаршилтай
4	Замбар /200 смx120 см	ш	2	/200 смx120 см/
5	Принтер 3 үйлдэлт	ш	2	Олон үйлдэлт лазер принтер USB/LAN/WiFi/ Duplex/ADF-50хуудас
6	Номын тавиур /өрөө/	ш	50	олон нүдтэй хананд тогтоох боломжтой, сайн чанарын шахмал модон хавтангаар хийгдсэн
3	Компьютер суурин /D	ш	2	Процессор/CPU: i7-8700(12M Cache,4.6 GHz),Шуурхай санах ой/RAM: 8GB BBR4 2666MHz (up to 32GB), Хатуу диск/HDD: 1TB 7200 rpm SATA 3Gb/s Hard Driver, График карт:Nvidia Geforce GTX1050 2GB,Оптик драйв:Tray load DVD Drive (Reads and Writes to DVD/CD),Сүлжээ:Integrated Giga bit 10/100/1000 Ethernet, Wireless: 1707 Card [802.11BGN+Bluetooth 4.0, 2.4 GHz], Multimedia Keyboard - KB216 MS116 Wired Mouse Blak,дэлгэц: 24 инч

ХЯНАСАН: ХОХБТХ-ИЙН ДАРГА

Б.БАЯРСҮХ

БОЛОВСРУУЛСАН: ХОХБТХ-ИЙН ММЭРГЭЖИЛТЭН

Л.БАТГЭРЭЛ



## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТЫГ ОРУУЛАХ

2. **Баглаа, боодол:** [Нийлүүлэх барааны үйлдвэрийн баглаа, боодлыг хөндөөгүй байх бөгөөд хэрэв хөндсөн байвал барааг хүлээн авахаас татгалзаж гэрээг цуцлана.]

3. **Бараа хүргэх газар:** [Ховд аймгийн Жаргалант сум 7-р сургууль]

4. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

### БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
	<b>Ерөнхий боловсролын газрын 7-р сургуулийн дотуур байрны зөөлөн эдлэл, ор, урлагийн заалны тохижилт</b>		<b>ширхэг</b>	<b>Ховд аймаг жаргалант сум</b>	<b>2020 оны 10-р сарын 15</b>	<b>2020 оны 10-р сарын 15</b>	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |       |  |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших                             | 1.1.  | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1.  | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1.  | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1.  | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1.  | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[моо]</b> жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1.  | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1.  | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан моо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1.  | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1.  | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.  |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
  - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
  - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
  - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[тоо]**<sup>1</sup> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>2</sup> 9.1. Алданги оногдуулах хувь: **[0.05]**
- Алдангийн нийт дүн: **[5 хувь]**

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

<sup>2</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>4</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>3</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>4</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*